

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 0011
Утас: (976) 7272 0303

Цахим шуудан: admin@environment.ub.gov.mn
Цахим хуудас: www.environment.ub.gov.mn

2024.07.08 № 06/2001

танай _____-ны № _____-т

Тендерийн баримт бичигт өөрчлөлт
оруулах тухай

Нийслэлийн Байгаль орчны газраас 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр tender.gov.mn цахим системээр зарласан “Хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулах /10 га/” ажлын НБОГ/20240101006 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.12, 20 дугаар зүйлийн 20.7 дахь заалтыг үндэслэн дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1. ТШЗ 19.1-д: 1.Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: Шаардана. Төслийг хэрэгжүүлэх багийн инженер, техникийн ажилтнуудын чадварын мэдээллийг дэлгэрэнгүй агуулсан танилцуулга ирүүлэх.

| № | Мэргэжил | Хүний тоо | Ажлын туршлага /жилээр/ | Үндсэн ажилтан эсэх |
|---|--|-----------|-------------------------|---------------------|
| 1 | Хөрс судлаач | 1 | 3 буюу түүнээс дээш жил | Үндсэн болон гэрээт |
| 2 | Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн | 1 | 3 буюу түүнээс дээш жил | Үндсэн болон гэрээт |
| 3 | Ургамал судлаач | 1 | 3 буюу түүнээс дээш жил | Үндсэн болон гэрээт |
| 4 | Микробиологич | 1 | 3 буюу түүнээс дээш жил | Үндсэн болон гэрээт |
| 5 | Химич, химийн технологич | 1 | 3 буюу түүнээс дээш жил | Үндсэн болон гэрээт |
| 6 | Биологич | 1 | 3 буюу түүнээс дээш жил | Үндсэн болон гэрээт |

/Дээрхийн заавал нэг нь үндсэн байх/

2. ТШЗ 19.3-д: Тусгай зөвшөөрөл: Шаардана.

- Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхтэй

- Байгаль орчны чиглэлийн мэргэжлийн байгууллагын эрхтэй
- Байгаль орчны үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй байгууллага
- Судалгаа шинжилгээний хүрээлэн, төв
- Их дээд сургууль
- Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түншлэл хэлбэрээр оролцож болно.

3. III. Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага хэсэгт: Нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн №02 дугаар “Хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулах” ажлын даалгаврыг эцсийн хувилбар гэж тооцно.